

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2019 оны 7сарын дугаар

Тэргүүн мэдээ.

Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анханы олон улсын хурал-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Ази, Номхон далайн бүсийн IV конгресс болов. Төлөөлөгчийн газрын дарга Тамүра, төслийн ахлах зөвлөх Чиба нар үг хэлэв.



7 сарын 2, 3-ны өдрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази номхон далайн бүсийн 4-р конгресс болов.

Энэхүү конгрессийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор бүс нутгийн хэмжээнд мэдлэг, туршлагаа хуваалцахын тулд зохион байгуулдаг юм. 2015 онд Японд болсон бөгөөд энэ удаа монгол улс зохион байгуулж буй уг хуралд дотоодын 200, гадаадын 400 төлөөлөгч оролцов. Конгрессийг нээж ерөнхий сайд У.Хүрэлсүх мэндчилгээ дэвшүүлж, ХНХ-ын сайд С.Чинзориг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулав.

7 сарын 3-ны өдрийн "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны жишээнээс суралцах" сэдэвт хуралдаан дээр ЖАЙКА-ийн Төлөөлөгчийн газрын дарга Тамүра Эрико ЖАЙКА-аас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулж, дараа нь "Улаанбаатар хот дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төслийн" ахлах зөвлөх Чиба төслийнхөө үйл ажиллагааг танилцуулав. Тэрчлэн салбар хуралдаан дээр уг төслийн мэргэжилтэн Хигашида Масатэру Монгол дахь ХБИ-н цагаан номын талаар танилцуулга хийж, Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төслийн ахлах зөвлөх Иший хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх танхимын үйл ажиллагааг танилцуулав.

Төслийн хэрэгжилт.

Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын менежментийг хэрэгжүүлэх эрхийг Японы 4 компанид олгож, гэрээнд гарын үсэг зурав.



7 сарын 5-ны өдөр иений хөнгөлөлттэй зээлээр баригдсан Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын менежментийн эрхийн гэрээнд гарын үсэг зурах ёслол болж, Монголын засгийн газар болон Японы 4 компани (Mitsubishi Shoji, Narita International Airport, Japan Airport Building, JALUX) хөрөнгө оруулалт хийж, менежментийг хэрэгжүүлэхээр болов. Гэрээнд гарын үсэг зурах ёслол дээр Монгол улсын ерөнхий сайд У.Хүрэлсүх, Японы элчин сайд Такаока Масато нар үг хэлж, хөгжлийн албан ёсны тусламжийн самбар нээх ёслол болов. ЖАЙКА шинэ нисэх буудлыг барих, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр хэрэгжүүлж ирсэн хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн нисэх буудлын үйл ажиллагааг даруй эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

(ТХА) Анхан ба хоёр дахь шатлалын төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн мэргэжилтэн хүндэт тэмдэгээр шагнуулав.



7 сарын 4-ний өдөр (ТХА) Анхан ба хоёр дахь шатлалын төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн мэргэжилтэн (зохицуулагч) Нозакид Монгол улсын эрүүл мэндийн салбарт ихээхэн хувь нэмэр оруулсан гадаадын иргэдэд олгодог ЭМЯ-ны хүндэт тэмдэгийг Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн гардуулав. Дэд сайд монголд анханы цогц оношлогооны сургалт зохион байгуулах зэргээр 2 жилийн хугацаанд ихээхэн ахицтай ажилласан төслийн үйл ажиллагааг дэмжиж ирсэн Нозаки мэргэжилтэнд талархал илэрхийлсэн бөгөөд Нозаки мэргэжилтэний зүгээс Монгол талын хамтран ажиллагчдад талархал илэрхийлэхийн хамт төслийн амжилт, үр дүнд итгэл дүүрэн байгаагаа илэрхийлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4-р конгрессийг угтсан арга хэмжээ зохион байгуулав.



Дээр танилцуулсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4-р конгрессийг угтан “Улаанбаатар хот дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төслийн” зүгээс Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар авч буй арга хэмжээ болон ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны талаар танилцуулах арга хэмжээ зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Монголын төрийн захиргааны ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, Япон талын холбогдох хүмүүс зэрэг 200 гаруй хүн оролцсон бөгөөд ЖАЙКА-ийн зүгээс Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр өнөө хүртэл хэрэгжүүлж ирсэн арга хэмжээг тоймлон танилцуулах үнэт боломжийг олгосон арга хэмжээ болов.

Татвар хураалтын үйл ажиллагаа, олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох төслийн хамтарсан удирдах хорооны 5 дугаар хурал болов.



6 сарын 27-ны өдөр хамтарсан удирдах хорооны 5 дугаар хурал болж төслийн хэрэгжилтийн явц байдлыг танилцуулахын хамт сурталчилгааны үйл ажиллагаа, байцаагчдад зориулсан сургалт зохион байгуулах, олон улсын татвар ногдуулалтын бодит жишээнүүдийн эмхэтгэл боловсруулах зэрэг цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөг авч хэлэлцэв. Тэрчлэн энэхүү төслөөс гаргасан зөвлөмжийг үндэслэн урт хугацаанд шийдэж чадахгүй авж ирсэн татварын өрийг барагдуулах ажлыг сайжруулах замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх, ТЕГ эрх мэдлийг бэхжүүлэх, татвар төлөгчдийг хамгаалах, татвар төлөлтийг хойшлуулах тогтолцоо зэрэг нэмэлт өөрчлөлт оруулсан татварын хууль 2019 оны 3 сард батлагдсан бөгөөд 2020 оны 1 сараас хэрэгжиж эхлэх гэж байгаа юм. Нэмэлт өөрчлөлт оруулсан татварын хуулийг саадгүй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь цаашид явуулах үйл ажиллагааны чухал хэсэг байна гэдэг дээр хоёр тал санал нэгдэв.

Дулаан тусгаарлагч будаг ашиглах төслийн судалгаа (ЖДҮ-ийн үйл ажиллагааг гадаадад өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл) эхлэв.



ЖДҮ-ийн үйл ажиллагааг гадаадад өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төслийн хүрээнд “Дулаан тусгаарлагч будаг ашиглан халаалтын хэрэгцээ ба агаарын бохирдлыг бууруулах төслийн судалгаа”-ны Монгол дахь эхний судалгаа хийгдэв. Энэ судалгааны хүрээнд Улаанбаатар хотод ужиграад байгаа агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэх чиглэлд Фүкүшима мужийн Иваки хотын Шимизү ХК-ний дулаан тусгаарлагч будгийн дулаан хадгалалтын болон эрчим хүчний хэмнэлтийн үр нөлөөг магадлан нүүрсний хэрэглээг багасгах, агаарын бохирдлыг бууруулахад үзүүлэх үр нөлөөг нь судлах юм. 2020 оны 4 сар хүртэл Монголд 3 удаа судалгаа хийж санал болгож буй бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэхийн зэрэгцээ Монголд бизнес болгон хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна.

ЦЕГ-тай хамтран аюулгүй жолоодлогыг уриалсан “Happy аав” дууг гаргалаа.



Монгол улс 3.2 сая хүн амтай боловч зам тээврийн ослоор нас барсан хүний тоо жилд дунджаар 500-600 хүн хүрч байгаа нь маш өндөр тоо юм. Өөрөөр хэлбэл 10 мянган хүн тутамд 16-20 хүн жил бүр амь насаа алдаж байна гэсэн үг. Энэ нь Японд “Зам тээврийн дайн” гэгдэж байсан 1970 оныхоос өндөр үзүүлэлт юм. ЖАЙКА нь Замын цагдаагийн газартай хамтран зам тээврийн осол үйлдэгчдийн 60%-ийг эзэлдэг 18-34 насны залуучуудад зориулан “Happy Аав” дууг зохиож нийтийн хүртээл болгосон. Энэ дууг залуу үеийнхэн сонсох дуртай дуучин GEE болон NAKI –аар дуулуулсан ба Аюулгүй жолоодлогыг эрхэмлэдэг Аав хүнийг дууныхаа гол дүр болгосон.

Доорх Youtube link-ээр орж заавал сонирхоорой.

<https://www.youtube.com/watch?v=qFeT9JqQyhk>

Бусад төслийн үйл ажиллагаа.

- 7 сарын 16: Урт хугацааны мэргэжилтэн Нозаки Тамоцу (Анхан ба хоёр дахь шатлалын төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл) буцав.
- 7 сарын 27: Урт хугацааны мэргэжилтэн Такамура Мицуо ((ТХА) Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын хүний нөөц, ашиглалт, менежментийн чадавхийг сайжруулах төсөл) буцав.

ЖАЙКА-ын сайн дурын үйл ажиллагаа.

Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга. (Бадминтоны холбооны сайн дурын гишүүний үйл ажиллагаа)



Монголын Бадминтоны холбоонд илгээгдэн ажиллаж буй Нагай Айка сайн дурын гишүүн 6 сарын сүүлээр Улаанбаатар хотод болсон бадминтоны олон улсын тэмцээний (Mines Up-Total Mongolia International Challenge) ерөнхий шүүгчээр ажиллаа. Сайн дурын гишүүн маань Монголд бадминтоны техникийг хөгжүүлэх, дасгалжуулагч бэлтгэх, тэмцээн зохион байгуулдаг болох чиглэлээр ажиллаж байна. 2020 оны Токиогийн олимп хаяанд ирсэн тул 22 орны өндөр зэрэглэлийн тамирчид олимпын эрхийн оноо авахын төлөө өрсөлдөж, монголын үзэгчдэд дэлхийн түвшний тэмцээн үзэх завшаан таарав. Эрэгтэй ганцаарчилсан төрөлд Японы ахлах сургуулийн тамирчин (Нараока Коота) түрүүлсэн байна.

Сайн дурын бусад үйл ажиллагаа.

7сарын 23-ны өдөр 2019 оны 1-р ээлжийн дараах 12 сайн дурын гишүүн хүрэлцэн ирэв. Оосава Юко (Бага ангийн багш/Дархан-Уул аймаг, Оюуны ирээдүй цогцолбор сургууль), Шига Мэгуми (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд дэмжлэг үзүүлэх/Улаанбаатар хот, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо), Танака Күми(Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд дэмжлэг үзүүлэх /Дархан-Уул аймаг, Энэрэл цогцолбор сургууль), Накагава Эрико (Бага ангийн багш/Дундговь аймаг, Мандал сургууль), Мацумото Юй (Биеийн тамир/Орхон аймаг, Боловсрол соёл урлаг, спортын газар), Юки Юй (Архангай аймаг/Спорт сургууль), Ёда Саори (Биеийн тамир/Булган аймаг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль), Ватанабе Аяа (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд дэмжлэг үзүүлэх/Дархан-Уул аймаг, 7-р цэцэрлэг), Күбота Рё (Хөдөлгөөн засалч/Улаанбаатар хотын Өнө-Энх мэдрэлийн сэргээн засах эмнэлэг), Ямашита Ёшиаки (Бага ангийн багш/Орхон аймаг, 15 дугаар сургууль), Ая Рина (Биеийн тамир/Төв аймаг, 5 дугаар сургууль), Ишияма Саки (Бага ангийн багш/Төв аймаг, 8 дугаар сургууль)



ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн шинэ гишүүд.



1100 гаруй гишүүнтэй ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг ерөнхийлөгч, ажлын албаны даргыг оролцуулан удирдах зөвлөлийн 9 гишүүн, хяналтын зөвлөлийн 3 гишүүн удирдан явуулдаг. Энэ жилийн 3 сард болсон удирдах зөвлөл ба хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгуулиар удирдах зөвлөлийн 4 гишүүн, хяналтын зөвлөлийн 1 гишүүн шинээр сонгогдлоо. Үүнд: ЗГХЭГ-ын ажилтан Ё.Жаргалсайхан, Визкон аудит компаний захирал Л.Отгонбаяр, Амгалан амаржих газрын орлогч дарга А.Амартүвшин, Candy World компаний захирал Мөнхдэлгэр нар удирдах зөвлөлийн гишүүнээр, Эрчим хүчний зохицуулах газрын дотоод аудитын газрын дарга Цоодол хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгогдон, цаашид 3 жилийн хугацаанд хуучин гишүүдтэй хамтран ажиллах болов. ЖАЙКА-ийн Төлөөлөгчийн газрын зүгээс сургалт төгсөгчдийн холбооны үйл ажиллагаанд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлж явах болно.

Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА)
Монгол дахь төлөөлөгчийн газар.
Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс
(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)
Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 /E-mail: mg_oso_rep@jica.go.jp
Web: www.jica.go.jp/mongolia/index.html /FB: [JICA Mongolia](https://www.facebook.com/JICA.Mongolia)